

**БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

П.САЙНЗОРИГ

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ,
ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасан нь төрөөс баримтлах эдийн засгийн бодлого нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, нийгмийн хөгжлийг хангахыг зорилго болгох бөгөөд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийх худалдан авах ажиллагаа нь мөн үүнд чиглэсэн байх юм.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон харилцааг нарийвчлан зохицуулсан хуулийг 2000 онд, тус хуулийн гүйцэтгэл, хэрэгжилтийг хангах хүрээнд Бараа, ажлын гүйцэтгэгчийг сонгоход баримтлах журмыг Засгийн газар баталснаар тендер шалгаруулалтын харилцааны эрх зүйн орчин анх бүрдсэн. Тус хуулийг 2005 болон 2023 онд шинэчлэн найруулсан бөгөөд одоо 2023 онд шинэчлэн найруулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар энэхүү харилцааг зохицуулж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3.3.17-д “Төрийн худалдан авалтаар бичил, жижиг, дунд бизнесийг дэмжиж, шаардлагатай түүхий эд, тоног төхөөрөмжөөр хангаж, хэрэгцээтэй хүний нөөцийг бэлтгэн, мэргэжилтэй ажилчдын мэдээллийн сан бүрдүүлнэ” гэж, 3.3.18-д “Томоохон аж ахуйн нэгж, төрийн худалдан авалтын гэрээг үндэслэн бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид зээлийн барьцаа шаардахгүйгээр зээл олгох нөхцөл бүрдүүлнэ” гэж, 6.4.6-д “Төрийн худалдан авалтыг ногоон худалдан авалтад үе шаттайгаар шилжүүлж, хувийн хэвшлийг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ” гэж тус тус заасан байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3.13-т “Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжиж, худалдан авах бүтээгдэхүүний төсөвт өртгийг зах зээлийн үнэлгээнд нийцүүлнэ” гэж, 2.3.3.3-т “Эмийн худалдан авалтад үнийн хэлцэл хийх, олон улсын байгууллагаар дамжуулан худалдан авах, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн эмийн зохицуулалтын эрх бүхий

байгууллагатай гадаад улсаас эм, эмнэлгийн хэрэгсэл шууд худалдан авах тогтолцоог бүрдүүлнэ” гэж, 3.1.2.2-т “Эдийн засгийн нийт нөөц, улирлын онцлогтой нийцүүлэн төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбэ, дарааллыг оновчилж, нийгэм, эдийн засгийн салбарт оролцох хүрээ, хязгаарыг хуулиар тогтоож, төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцоог оновчтой болгож, хиймэл оюун ухааныг ашиглана” гэж тус тус заасан байна.

Түүнчлэн тус хөтөлбөрийн дагуу Монгол Улсын Засгийн газар 2024-2028 онд хилийн боомтуудад төмөр зам барих, дулааны болон усан цахилгаан станц барих, зэс боловсруулах үйлдвэр болон гангийн цогцолборыг ашиглалтад оруулах зэрэг эрчим хүч, уул уурхай, хүнд үйлдвэрийг хөгжүүлэхэд чиглэсэн 14 мега төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс гадна Нийслэлийн Засаг дарга 2025-2028 онд автозамын түгжрэл болон агаарын бохирдол бууруулахад чиглэсэн 12 мега төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Улаанбаатар хотын мега төслүүдэд гүүр, хурдны зам, нийтийн тээврийн дэд бүтэц шинээр байгуулах, дулааны цахилгаан станц нэмж барих, гэр хорооллыг орон сууцжуулах зэрэг томоохон дэд бүтэц, бүтээн байгуулалтын төслүүд багтжээ.¹

Одоо хүчин төгөлдөр мөрдөж буй Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан тендер шалгаруулалтын аргууд нь дээр дурдсан мега төслүүдийг эхлүүлэх, тус төслүүдийг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад тохиромжгүй байгаа бөгөөд үндэсний хэмжээний томоохон төсөл хөтөлбөрийг өмнө ийм томоохон хэмжээний төсөл хэрэгжүүлж байсан гадаадын хуулийн этгээдтэй хамтран хэрэгжүүлэхийн тулд олон улсад хүлээн хэрэглэгддэг тендер шалгаруулалтын аргуудаас нэвтрүүлэх зайлшгүй шаардлага бий болсон байна.

Түүнчлэн гадаадын гүйцэтгэгчтэй хамтран ажиллах нь мега төслүүдийн хувьд гарцаагүй бөгөөд түүнтэй уялдуулан худалдан авалтын гэрээний эрх зүйн харилцааг олон улсын жишигт нийцүүлэх, Олон Улсын Инженерүүдийн холбооноос боловсруулсан ФИДИК зэрэг загвар гэрээг хэрэглэх боломжийг нээх, түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ байгуулахыг тодорхой тохиолдолд зөвшөөрөх зэрэг гэрээний нөхцөлийг хуульд заасан стандарт нөхцөлөөс өөрөөр хэлэлцэн тохиролцох боломжтой болгох, мөн гадаад валютаар үнэ тогтоож, төлбөр тооцоо хийх зэрэг зохицуулалт зайлшгүй шаардлагатай байна.

Хүн амын эрүүл мэндтэй холбоотой нэн чухал эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн зэргийг худалдан авах ажиллагаанд цаг хугацаа их зарцуулагдаж байна. Мөн захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээнд тавигдах шалгуурыг хангалтгүй боловсруулж, стандарт, дүрмийг бүрэн ашиглаж, мөрдөхгүй байгаа нь хамгийн бага үнийн дүн бүхий хэдий ч хүссэн чанарт хүрэхгүй, үр ашиггүй худалдан авалт хийх тохиолдлыг нэмэгдүүлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг шинэчлэн найруулсан боловч төрийн худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулсан нийт тендер шалгаруулалтын 50-аас дээш

¹ Нийслэлийн Засаг Даргын Тамгын газраас өгсөн мэдээлэл. 2025.

хувь нь амжилтгүй болсон тохиолдол сүүлийн гурван жилийн хугацаанд нийтлэг байна.²

Мөн тендерт оролцогчдоос Сангийн яаманд гаргасан гомдолд шинжилгээ хийж үзэхэд тус яаманд гаргах гомдлын тоо жилээс жилд өссөн байна. Тухайлбал 2024 оны 11 дүгээр сарын байдлаар Сангийн яаманд 2453 гомдол ирсэн ба энэ нь өмнөх онуудад гаргасан гомдлын тооноос даруй 400 гаруйгаар нэмэгдсэн байна. Үүнээс үзвэл хуулийг 2023 онд шинэчлэн найруулж батлахдаа гомдол шийдвэрлэх ажиллагааг оновчтой болгохоор үзэл баримтлалд тусгасан хэдий ч энэхүү нөхцөл байдал бүрэн шийдвэрлэгдээгүй гэж үзэхээр байна. Мөн Сангийн яамнаас шийдвэрлэсэн гомдлын 80 хувьд³ нь гомдол гаргагчийн гомдол үндэслэлтэй гэж шийдвэрлэгддэг буюу захиалагчийн буруутай байдал ажиглагдаж байна.

Оролцогч тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг шүүхийн өмнөх урьдчилан шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлүүлэхдээ олонхын зарчмаар хэлэлцэн шийдвэрлүүлэхийг илүүд үздэг. Иймд энэ төрлийн маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хараат бус, дагнасан зөвлөл олонхын зарчмаар шийдвэрлэдэг болсноор гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаа олон улсын сайн жишигт нийцэх юм.

Дэлхий нийтийн чиг хандлага болсон ногоон худалдан авах ажиллагаа хийгдэхэд бэрхшээлтэй байгаа буюу ногоон худалдан авалтад чиглэсэн зохицуулалт байхгүй байна. Хэдийгээр шинэчлэн найруулж баталсан хуульд энэ талаарх зохицуулалтын суурийг тавьсан боловч хэрэгжүүлэх механизмыг хуулиар зохицуулаагүйгээс шалтгаалан төрийн ногоон худалдан авалт хийгдэхгүй байна. Энэ нь Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлж, хүлэмжийн хийг бууруулах ажиллагаанд нэг алхам ойртох нөхцөлийг бий болгох тул үүнийг ойлгомжтой тодорхой, ногоон худалдан авалтыг нэн тэргүүнд тавьдаг болох нөхцөлийг бий болгох шаардлагатай байна.

Орчин үеийн технологи, дэвшилтээр түгээмэл хэрэглэгдэж байгаа цахим дэлгүүр, хиймэл оюуныг тендер шалгаруулалтад ашиглаж байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлэх шаардлага байна. Ингэснээр төсөв болон цаг хугацаа хэмнэх, аж ахуй эрхлэгч тендер илгээхэд хялбар болно.

Худалдан авах ажиллагааны цахим системээр давхардсан тоогоор 2024 онд 53,377 тендер шалгаруулалт зохион байгуулагдсан бөгөөд үүнээс 10 тэрбум хүртэлх төсөвт өртөгтэй тендер шалгаруулалт 52,936 байсан буюу 99.1 хувь байсан байна. Аж ахуй эрхлэгч 100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад оролцоход 0,5 хувьтай тэнцүү хэмжээний баталгаа байршуулах шаардлагатай бөгөөд 2024 онд 277 тэрбум төгрөгийг банкны баталгаа хэлбэрээр байршуулж, үүний төлбөрт 9.4 тэрбум төгрөгийг банканд төлсөн байна. Тендер оролцогчдын зардал үүнтэй холбоотойгоор болон тендер бэлтгэхтэй холбоотойгоор тогтмол өсөж байгаа нь өрсөлдөөнийг бууруулж, тендер шалгаруулалтад оролцогчдын тоо хоёроос доош болж, тендер шалгаруулалт амжилтгүй болох нөхцөлийг бүрдүүлж байна.

² Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд зарчмын шинжтэй зохицуулалт шинээр нэмж оруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан. 2024 он.

³ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд зарчмын шинжтэй зохицуулалт шинээр нэмж оруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан. 2024 он.

Хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгаанд хуульд зарим зохицуулалт хангалтгүй тусгагдсан тул мега төслийн тендер шалгаруулалт, тендер шалгаруулалтын ажиллагааг боловсронгуй болгох, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, гомдол шийдвэрлэхтэй холбоотой зарчмын шинжтэй зарим өөрчлөлтүүдийг оруулах нь зүйтэй гэж дүгнэжээ. Дээр дурдсан хууль зүйн үндэслэл, практик хэрэгцээ, шаардлагыг үндэслэн зарчмын болон бусад найруулгын шинжтэй өөрчлөлтүүдийг хийхэд хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орохоор байгаа тул хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна.

Түүнчлэн тус хуульд “захиалагч”-ийг өргөн хүрээгээр тодорхойлсоор ирсний дагуу энэ хуулиар төрийн болон орон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийх худалдан авалтаас гадна төрийн болон орон нутгийн өмчит компани, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн худалдан авах ажиллагааг зохицуулдаг болохыг харгалзаж хуулийн нэрийг Худалдан авах ажиллагааны тухай гэж өөрчлөх нь оновчтой гэж үзлээ.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Худалдан авах ажиллагааны тухай хуулийн төслийн зорилго нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр болон энэ хуульд заасан захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, гэрээ байгуулах, тайлагнах, хяналт тавих, гомдол шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хуулийн төсөл 8 бүлэгтэй байх ба дараах асуудлыг тусгана. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт Нийтлэг үндэслэл буюу Төрийн худалдан авах ажиллагааны тухай хуулийн зорилго, хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, худалдан авах ажиллагааны зарчим, оролцогч, түншлэл, туслан гүйцэтгэгч, оролцогчийн ерөнхий шаардлагыг магадлах, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, давуу эрх олгох, худалдан авах ажиллагааны цахим системийн талаар тусгана.

Хоёрдугаар бүлэгт Тендер шалгаруулалт зохион байгуулах буюу тендер шалгаруулалтын зохион байгуулалт, баримт бичиг, техникийн тодорхойлолт, тус тодорхойлолтод нийцэхийг нотлох баримт, загвар, дээж, чадавхын болон туршлагын шаардлага, санхүүгийн чадавхын шаардлага, техникийн чадавх болон туршлагын шаардлага, тендер шалгаруулалтын зарлал, тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах, тендер хүлээн авах хугацаа, тендер бэлтгэх, тендер илгээх талаар зохицуулна.

Гуравдугаар бүлэгт Захиалагч шийдвэр гаргах буюу тендер нээх, захиалагч шийдвэр гаргах хугацаа, тендерийн талаар тодруулга авах, тендер хянан үзэх, тендер үнэлэх, захиалагч шийдвэр гаргах, түүнийг мэдэгдэх, тендер шалгаруулалтын мэдээллийг ил тод болгох, гэрээ байгуулах талаар тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт Тендер шалгаруулалтын аргын талаар зохицуулалтыг тусгана.

Тавдугаар бүлэгт Худалдан авах гэрээ, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, илт хууль бус гэрээ, гүйцэтгэлийн болон зүгшрүүлэх, тохируулах хугацааны баталгаа, урьдчилгаа төлбөр, түүний баталгааны талаар тусгана.

Зургаадугаар бүлэгт Худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах, тендер шалгаруулалтыг төвлөрүүлэн нэгтгэн зохион байгуулах, захиалагчийн эрх, үүрэг, худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага, үнэлгээний хорооны талаар тусгана.

Долдугаар бүлэгт Захиалагчид болон харьяалах гомдол хянан шийдвэрлэх байгууллагад гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхэд гомдол гаргах зохицуулалтын талаар тусгана.

Наймдугаар бүлэгт Бусад буюу хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох талаар тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дүн бий болно. Үүнд:

1. Ил тод, өрсөлдөөнт байдлыг бий болгож зах зээлийн үнээр чанартай бараа, ажил, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ. Аж ахуйн нэгжийн өрсөлдөх боломжийг нэмэгдүүлж тендер бэлтгэхэд бүрдүүлэх материалыг тоо цөөрүүлэх үүднээс хиймэл оюун, дэвшилтэд технологийг худалдан авах ажиллагаанд нэвтрүүлэх боломжийг нээнэ. Ингэснээр хувийн хэвшил төдийгүй, худалдан авах ажиллагаатай холбоотой төрийн байгууллагуудын зардлыг бууруулж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

2.Захиалагч чанартай, байгаль орчинд ээлтэй бараа, ажил худалдан авах хүсэлтэй бол зөвхөн эм, эмнэлгийн хэрэгслээр хязгаарлагдахгүй өөрийн боловсруулсан техникийн тодорхойлолтдоо үндэслэн чанар ба үнийн аргыг хэрэглэн тендерийг үнэлж, хэрэгцээ, шаардлага, урт хугацааны бодлогод нийцсэн худалдан авах хийх боломжтой болно.

3.Монгол Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан мега төслүүдийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Тендер шалгаруулалтын аргын төрлийг нэмснээр тендер шалгаруулалтыг тухайн тендерт тохирсон оновчтой аргаар явуулж, худалдан авалт амжилттай болох нөхцөл бүрдэнэ.

4.Монгол Улсын бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан мега төслүүдийг хэрэгжүүлэхэд ФИДИК зэрэг олон улсын нийтлэг хэрэглэгддэг жишиг гэрээний загварыг ашиглаж гэрээ байгуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

5.Тендер шалгаруулалтын талаар оролцогчдоос гаргасан гомдол, маргааныг урьдчилан шийдвэрлэх болон шүүхээс хянан шийдвэрлэхтэй холбоотой өөрчлөлт оруулснаар хэрэг хянан шийдвэрлэх хугацаа багасаж, хялбар, хурдан шуурхай болгох нөхцөл бүрдэнэ.

6. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй нөхцөлд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авч буй бүх ажиллагааг тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулдаг болсноор худалдан авалтыг оновчтой, үр ашигтай төлөвлөх, худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.

7.10 тэрбум төгрөгөөс доош үнийн дүн бүхий тендер шалгаруулалт, эсхүл түүнээс доош төсөвт өртөгтэй багцад оролцогч тендерийн баталгааны оронд мэдэгдэл гаргах боломжтой болсноор тендерт оролцох санхүүгийн зардал буурч, өрсөлдөөн нэмэгдэхэд эерэгээр нөлөөлнө.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Худалдан авах ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулна.

Худалдан авах ажиллагааны тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Автозамын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус дагалдуулан боловсруулна.

---o0o---